



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/180

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/21 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ундны эх үүсвэрийн хамгаалалтын объектод тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

О.Содовжамц

Худалдан авах ажиллагааны албаны
дарга

Гишүүд:

Э.Соёмбобат

Ерөнхий боловсролын “Хангай”
сургуулийн захирал

Б.Нарантуяа

Цагдаагийн хэлтсийн ахлах нягтлан
бодогч цагдаагийн ахмад

Д.Даваасамбуу

1 дүгээр хорооны иргэн

Нарийн бичиг:

Б.Тамир

Худалдан авах ажиллагааны албаны
Архивч, нярав, бичиг хэрэг хариуцсан
ажилтан

2. Хууль, тогтоомжийн дагуу ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсэг (О.Содовжамц)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД